

**БИО КОМБИНАТ ТӨААТҮГ-ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГАД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын код: САГ-2018/14/-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885

Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn

Аудитор Р.Цолмон

Утас: 261740

Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн

Захирал С.Тунгалаг

Утас: 70001778

Цахим хаяг: tungalag.s@imkaudit.mn

Чанарын хяналтын мэргэжилтэн: С.Сожидмаа

Утас 70001778

Цахим хаяг: sojidmaa.s@imkaudit.mn

Аудитор: Д.Пүрэвжаргал

Утас: 70001778

Цахим хаяг: purevjargal.d@imkaudit.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	1
2	Аудитын тайлан.....	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	4
2.5	Дотоод хяналт	5
2.6	Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	5
2.7	Шилэн дансны мэдээлэл	6
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	6
2.9.1	<i>Байгууллагын санхүүгийн тайланд тусгагдаж ирсэн тодорхойгүй эх үүсвэрүүд болон улсын бүртгэлийн талаар:</i>	6
2.9.2	<i>Мөнгөн хөрөнгийн талаар:</i>	7
2.9.3	<i>Бараа материалын талаар</i>	7
2.9.4	<i>Үндсэн хөрөнгийн талаар</i>	8
2.9.5	<i>Авлага, өр төлбөрийн талаар</i>	9
2.9.6	<i>Санхүүгийн тайлангийн талаар</i>	10
2.9.7	<i>Нягтлан бодох бүртгэлийн талаар</i>	11
2.9.8	<i>Шилэн дансны талаар</i>	11
2.9.9	<i>Төлөвлөгөө, зорилтот түвшний талаар</i>	11
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	12
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	12
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	13
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	13
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3	Менежментийн захидал	14
	Асуудал 1: Байгууллагын санхүүгийн тайланд тусгагдаж ирсэн тодорхойгүй эх үүсвэрүүд болон улсын бүртгэлийн талаар	15
	Асуудал 2: Мөнгөн хөрөнгийн талаар	17
	Асуудал 3: Бараа материалын талаар	18
	Асуудал 4: Үндсэн хөрөнгийн талаар.....	19
	Асуудал 5: Авлага өр төлбөрийн талаар	20
	Асуудал 6: Зардлын талаар	21
	Асуудал 7: Санхүүгийн тайлагналын талаар.....	22
	Асуудал 8: Нягтлан бодох бүртгэлийн талаар	23
	Асуудал 9: Шилэн дансны талаар.....	24
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшний биелэлт	25
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	25
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	26
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	1
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	1
4.5	Аудит хийгдсэн зорилтот түвшний биелэлт	2

1 Аудитын гэрчилгээ

БИОКОМБИНАТ ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.БАТТОГТОХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулгад, санхүүгийн тайлангийн аудит хийв.

Сөрөг санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Биокомбинат ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй, алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлтэй байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Биокомбинат ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

- Тайлант оны батлагдсан орлогын төлөвлөгөөг 12.8 хувиар буюу 789.7 сая төгрөгөөр тасалдуулсан;
- Нийт 67 байгууллагын 102.9 сая төгрөгийн авлага, 33 байгууллагын 40.3 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Санхүүгийн төлөвлөгөөнд баталсан захиалгын дүнгээс 151.7 сая төгрөгөөр илүү бараа материал бэлтгэсэн;
- Худалдан авсан 170.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэхдээ, худалдан авалтанд төлсөн 15.5 сая төгрөгийг нэмэгдсэн өртгийн албан татварыг капиталжуулаагүй;
- Даатгалын байгууллагатай байгуулсан гэрээний төлбөрт төлсөн 15.0 сая төгрөгийг тайлант оны зардлаар бүртгэсэн;
- Ногдол ашигт төлсөн 152.1 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд, төлсөн ногдол ашигаар тайлагнаагүй;
- Уралдаан тэмцээн, хүлээн авалт, баяр ёслолд үр ашиггүй 32.2 сая төгрөгийг зарцуулсан;
- Тушаал, шийдвэргүйгээр 38.1 сая төгрөгийн хоолны хөнгөлөлтийн зардлыг хэтрүүлсэн;
- Тус байгууллага нь 100 хувь төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар боловч нэмж төлөгдсөн капитал дансанд тодорхойгүй эх үүсвэр 124.7 сая төгрөгийг тайлагнаж ирсэн;
- Мөнгөн гүйлгээний тайланд борлуулалтын орлогыг 81.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.
Дээрх зөрчлүүд нь санхүүгийн тайлагналын оршин байх, үнэн зөв байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Биокомбинат ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу, тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Биокомбинат ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг Биокомбинат ТӨААТҮГ-ын захирал Б.Баттогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн байгууллагын санхүүгийн тайланд тусгагдаж ирсэн тодорхойгүй эх үүсвэрүүд болон улсын бүртгэл, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өр төлбөр, зардал, санхүүгийн талагнал, нягтлан бодох бүртгэл, шилэн данс, төлөвлөгөө, зорилтот түвшний талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Биокомбинат ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Биокомбинат ТӨААТҮГ-ын удирдлага жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн жилийн эцсийн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 14-нд эцэслэн баталгаажуулж, Биокомбинат ТӨААТҮГ-ын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, "Их Монгол Улсын Аудит" ХХК-ийн аудитор Д.Пүрэвжаргал, аудиторын туслах Т.Оюун, аудиторын туслах М.Батжаргал, С.Өлзийжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.



Биокомбинат ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 1/65 дугаар албан бичгээр “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 1 сарын 10-ны өдрийн А-05 дугаар тушаалаар томилогдсон шалгалтын комисс санхүүгийн баримт материалыг битүүмжилж, 2017 оны 3 дугаар сарын 07-ны өдөр хүлээлгэн өгсөн тул аудитыг хуулийн хугацаанд хийх боломжийг алдагдуулсан.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Биокомбинат ТӨААТҮГ нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Эмийн тухай хууль, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Биокомбинат ТӨААТҮГ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан гэрээ, зорилтот түвшний үзүүлэлтийг ханган биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, өөрийн орлогоор зардлаа санхүүжүүлэн ажилладаг.

Биокомбинат ТӨААТҮГ-ын эрхэм зорилго нь мал, амьтныг халдварт өвчнөөс сэргийлэх, оношлох, эмчлэх биобэлдмэлийн үйлдвэрлэлийг шинжилгээ судалгаанд суурилан эрхлэхэд оршино гэж тодорхойлжээ.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлийн нэг болох биотехнологийн зарчимд тулгуурлан, орчин үеийн шаардлагад нийцүүлсэн барилга байгууламж, дэвшилтэт технологи, мэргэжлийн чадварлаг хамт олны бүрэлдэхүүнтэйгээр сайн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Монгол Улсын мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тодорхой хувь нэмэр оруулах зорилттой.


Биокомбинат ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Шинжлэх ухаан үйлдвэрлэлийн амин чухал холбоог бодитой ажил хэрэг болгож, өөрийн орны эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудтай нягт хамтран ажиллахын зэрэгцээ, үйлдвэрлэлд сүүлийн үеийн дэлхийн биобэлдмэлийн дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлж, 2-4 өвчний эсрэг үйлчилгээтэй олон цэнэгт вакцины технологийг боловсруулах, Монгол Улсад урьд өмнө үйлдвэрлэгдэж байгаагүй ч олон жилийн судалгаагаар нэн чухал хэрэгцээтэй байгаа нь тогтоогдсон зарим халдварт өвчнөөс сэргийлэх вакцинуудыг шинээр үйлдвэрлэх, бүтээгдэхүүний технологийг шинэчлэх, чанарыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Биокомбинат ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн



нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Биокомбинат ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 11 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 36 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Биокомбинат ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Биокомбинат ТӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулсан нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.


Биокомбинат ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Дунд” гэж үзлээ.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хяналт, үнэлгээ дотоод аудитын газраас 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 24-ний өдөр хяналт шинжилгээ үнэлэгээний ажлыг гүйцэтгэж 17 зөвлөмж өгсөн байна. Үүнээс нягтлан бодох бүртгэлийн талаар байгууллагынхаа онцлогт тохируулан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталгаажуулах, дансдын харьцааг тодорхой тусгах гэсэн зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй, дотоод хяналтын ажилтан С.Ууганцэцэг нь зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгүй, хэрэгжүүлсэн тодорхой ажилгүй байна.

Биокомбинат ТӨААТҮГ-ын 2010 оноос хойшхи санхүүгийн тайлангийн өндөлөнгийн аудитын дүгнэлт болон хяналт шалгалтын дүнтэй танилцах, 2016-2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, ёс зүйн асуудалд дүн шинжилгээ хийж, арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Мал эмнэлэг үржлийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газруудын 17 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 1 сарын 10-ны өдрийн А-05 дугаар тушаалаар томилогдон ажиллаж байна.

2.6 Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Биокомбинат ТӨААТҮГ-ын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 203 дугаар тогтоолоор баталсныг, 2017 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 379 дугаар тогтоолоор тодотгол хийн дахин баталсан байна. Тогтоолын 1 дүгээр хавсралтаар 6,195.9 сая төгрөгийн орлого, 5,948.1 сая төгрөгийн зардалтай, 223.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар баталсан байна.



Биокомбинат ТӨААТҮГ нь тайлант онд 5,406.2 сая төгрөгийн нийт орлого, 5,058.4 сая төгрөгийн зардалтай, 37.2 сая төгрөгийн татвар төлж 310.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн зорилтот түвшин, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, санхүүжилт зэрэг нийт 18 мэдээллийг байршуулахаас санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангаас бусад 15 үзүүлэлтийг байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 36 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Байгууллагын санхүүгийн тайланд тусгагдаж ирсэн тодорхойгүй эх үүсвэрүүд болон улсын бүртгэлийн талаар:

- Тус байгууллага нь 100 хувь төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдэрийн газар боловч нэмж төлөгдсөн капитал дансанд тодорхойгүй эх үүсвэр 124.7 сая төгрөгийг тайлагнаж ирсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 2-т нэмж төлөгдсөн капитал нь компанийн гаргасан энгийн хувьцаа болон давуу эрхтэй хувьцааны зах зээлийн үнэ нэрлэсэн үнээс илүү байвал зөрүүг нэмж төлөгдсөн капитал дансанд хуримтлуулан бүртгэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэж заасныг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тодорхойгүй эх үүсвэрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх.

- Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг дансанд тодорхойгүй эх үүсвэр 207.9 сая төгрөгийг тайлагнаж ирсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 17-д “Эздийн өмчийн бусад хэсэг”-ийн бүрэлдэхүүн тус бүр (тухайлбал, ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн тогтоосон төлөвлөгөөнөөс үүссэн актаур олз, гарз, санхүүгийн хэрэглүүрийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарз, мөнгөн гүйлгээний хейдж дэхь хейджийн хэрэглүүрээс үүссэн олз, гарз) гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тодорхойгүй эх үүсвэрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх.

- Тус байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 300 гишүүнтэйгээр бүртгэгдсэн нь Төрийн өмчийн хорооны 2004 оны 432 дугаар тогтоолоор баталсан байгууллагын

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ

дүрмийн 4.1-т "Үйлдвэрийн газрын хөрөнгө нь дан ганц төрийн өмчийн эд хөрөнгөөс бүрдэх бөгөөд нийт хөрөнгө нь үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгө, биет бус хөрөнгөөс бүрдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уламжлан шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх.

- Эзэмшигчийн өмчийг санхүүгийн байдлын тайланд 2,141.0 сая төгрөгөөр тайлагнасан нь улсын бүртгэлийн гэрчилгээнд 1,233.6 сая төгрөгөөр бүртгэсэн дүнгээс 907.4 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төрийн өмчийн хорооны 2004 оны 432 дугаар тогтоолоор баталсан байгууллагын дүрмийн 4.2-т "Үйлдвэрийн газрын хөрөнгийн хэмжээнд гарах өөрчлөлтийг жил бүрийн санхүүгийн тайлан тэнцэлд тусгана" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уламжлан шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх.

- Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацааг 1 жилээр бүртгүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уламжлан шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх.

2.9.2 Мөнгөн хөрөнгийн талаар:

- Нийт 131.8 сая төгрөгийг бэлэн мөнгөний орлогын баримтгүй, 8.3 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.4-т "Аж ахуй нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ" гэж заасныг болон санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээ бүрийг хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн бүртгэж байх зөвлөмж өгөх

- Томилолтын зардалд баримтын бүрдэл дутуу 1.3 сая төгрөгийг бодож олгосон байна. Энэ нь Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 22 ны өдрийн 218 дугаар тогтоолын 3.9-д "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог томилолтын үнэмлэхэд тэмдэглэсэн календарийн өдрийн бүх хоногоор тооцож гаргана. Тэгэхдээ явсан, буцаж ирсэн өдрийг нэг хоногт тооцно." гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээ бүрийг хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн бүртгэж байх талаар зөвлөмж өгөх.

2.9.3 Бараа материалын талаар

- Бараа материалын үлдэгдлээс 5 нэр төрлийн хөрөнгөнд хяналтын тооллого хийхэд 2 нэр төрлийн 1.4 сая төгрөгийн бараа материал илүү, 4 нэр төрлийн 7.3 сая төгрөгийн бараа материал дутуу, 3 нэр төрлийн 20.5 сая төгрөгийн бараа материалын хадгалалтын хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэж заасныг мөрдөөгүй байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ

Шийдвэрлэсэн нь: Бараа материалыг үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөнд баталсан хэмжээ, тухайн үеийн хэрэгцээ шаардлага, ашиглах хугацаа зэргийг харгалзан бэлтгэж байх талаар зөвлөмж өгөх

- Хугацаа нь дууссан 3 нэр төрлийн 10 орчим тн 9.3 сая төгрөгийн химийн бодисын үлдэгдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа хэтэрсэн ашиглах боломжгүй химийн бодисын талаар шийдвэрийг гаргуулах зөвлөмж өгөх.

- 2017 онд 247.1 сая төгрөгийн гологдол бүтээгдэхүүн, 121.0 сая төгрөгийн шинжилгээний дээжид ашигласан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн өртөгт шингээж бичилт хийсэн байна. Энэ нь байгууллагын мөрдөж байгаа НБББББ-ийн бараа материалын бүртгэлийн бодлогын зарцуулалтын өртөг “бараа материалын хэвийн хорогдлыг үйл ажиллагааны бус зардалд дундаж өртгөөр, акталж устгасан зүйлийг үйл ажиллагааны бус зардалд дундаж өртгөөр” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэлийн өртөгт оруулан тооцсон гологдол бүтээгдэхүүнийг үйл ажиллагааны бус зардалд бүртгэж байх талаар зөвлөмж өгөх

- 2017 оны жилийн эцсийн тооллогоор 73 нэр төрлийн 9.1 сая төгрөгийн бараа материалыг тооллогын комисс актлах шийдвэр гаргасан боловч, байгууллагын захирлын тушаалгүй тул данс бүртгэлээс хасаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалыг данснаас хасах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр гаргуулах талаар зөвлөмж өгөх.

2.9.4 Үндсэн хөрөнгийн талаар


- Байгууллагын баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох арга, ашиглах жилийг тусгаж өгөөгүй нь Засгийн газрын 2014 оны 297 дугаар тогтоолыг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн НБББББ-т нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөх талаар зөвлөмж өгөх.

- Худалдан авсан 170.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэхдээ худалдан авалтанд төлсөн 15.5 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг капиталжуулаагүй, нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан авалтаар бүртгэсэн байна. Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр бүлгийн 1.5-д “үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийг капиталжуулах, татварын байгууллагад хүсэлт илгээн нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд залруулж бүртгэх талаар зөвлөмж өгөх.

- Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлагад үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн 187.4 сая төгрөгөөс 61.4 сая төгрөгийг дутуу тайлагнасан нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын нэгдүгээр



хавсралт "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын "Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланг залруулах талаар зөвлөмж өгөх.

- Үндсэн хөрөнгийн дансанд нийт 448 төрлийн нийт 3128 ширхэг элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1,862.7 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, данс бүртгэлээс хасах зэрэг асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх

2.9.5 Авлага, өр төлбөрийн талаар

- Бүүвэй фүүд" ХХК-тай байгуулсан цайны газрыг түрээслүүлэх гэрээний 3.2-т "Цайны газрыг түрээслэхэд барьцаа болгож гурван сарын түрээсийн төлбөр болох 4.8 сая төгрөгийг байгууллагын дансанд байршуулах гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагуудтай хийсэн гэрээний заалтыг мөрдөж ажиллах, гэрээг дүгнэж байх талаар зөвлөмж өгөх.

- Ажилтан албан хаагчдад олгосон 500.6 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг тооцооны дансаар дамжуулж бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох журам, зааварт тусгасны дагуу нягтлан бодох бүртгэлд бүртгэж байх талаар зөвлөмж өгөх.

- Цалингийн урьдчилгааг тооцооны дансанд бүртгээгүйгээс үүссэн гүйлгээний утга тодорхойгүй 21.2 сая төгрөгийг авлага дансанд хаасан байна.


Шийдвэрлэсэн нь: Авлагыг дэлгэрэнгүй нэрээр залруулж бүртгэх талаар зөвлөмж өгөх.

- Тайлант онд 67 байгууллагатай холбоотой 103.0 сая төгрөгийн авлага, 33 байгууллагатай холбоотой 40.4 сая төгрөгийн өр төлбөрийг тус тус тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д Ерөнхий нягтлан бодогч нь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" үүрэгтэй гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, барагдуулж ажиллах албан шаардлага өгөх

Зардлын талаар

- Практикал даатгал ХХК-тай байгуулсан 1 жилийн даатгалын гэрээний төлбөрт төлсөн 15.0 сая төгрөгийг тайлант оны зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалын 2.1.5-ын Г-д "Урьдчилж төлсөн зардлыг хэрэгжсэн үед тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө", 2012 оны 77 дугаар тушаалын 7-д "Тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг урьдчилж төлсөн зарлагыг (даатгал, түрээс) гэх мэт санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулж урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн



зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд шингээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Даатгалын хураамжийг урьдчилж төлсөн зардлаар бүртгэж байх талаар зөвлөмж өгөх

- Ажилтан албан хаагчдад ажлын өдөрт нэг мянга таван зуун төгрөгийн хоолны хөнгөлөлт олгохоор хөдөлмөрийн дотоод журмын цалин хөлсний бодлого горимд заасан боловч, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулаагүй, тушаал шийдвэргүйгээр гурван мянган төгрөгөөр тооцож олгосноос 38.1 сая төгрөгийг илүү олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Хоолны хөнгөлөлтийг байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, тушаал шийдвэрээр баталгаажуулах талаар зөвлөмж өгөх.

- Уралдаан тэмцээнд 11.2 сая, хүлээн авалтын зардалд 11.5 сая, баяр ёслолын зардалд 13.5 сая, нийт 32.2 сая төгрөгийг зарцуулсан нь Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын нэгдүгээр хэсэгт “...төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах...” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид үр ашиггүй зардал гаргахгүй ажиллах талаар зөвлөмж өгөх

2.9.6 Санхүүгийн тайлангийн талаар

- Орлогын дэлгэрэнгүй тайланд тусгасан 5,373.9 сая төгрөгийн борлуулалтын орлого нь гүйлгээ балансаархи борлуулалтын орлогын дүнгээс 1.1 сая төгрөгөөр илүү, нэмэгдсэн өртгийн албан татварт 5,305.9 сая төгрөгөөр тайлагнасан борлуулалтын орлого нь санхүүгийн тайлангийн борлуулалтын орлогоос 68.0 сая төгрөгөөр дутуу тайлагнагдсан нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйлгээ баланс болон татварын тайланд залруулах бичилт хийх талаар зөвлөмж өгөх.


- Ногдол ашигт төлсөн 152.1 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд төлсөн ногдол ашигт тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаж байх талаар зөвлөмж өгөх.

- Санхүүгийн байдлын тайланд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг санхүүгийн тайлангийн тодруулгад 36.2 сая төгрөгөөр, аж ахуй нэгжийн орлогын албан татварын авлагыг 8.8 сая төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татварын авлагыг 7.7 сая төгрөгөөр, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын өглөгийг 0.01 сая төгрөгөөр, хувь хүнээс суутгасан орлогын албан татварын өглөгийг 3.4 сая төгрөгөөр цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын өглөгийг 1.7 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

Хувь хүний орлогын албан татварт төлөх 26.6 сая төгрөгийн татварыг үл хөдлөх хөрөнгийн татварт шилжүүлснээс үл хөдлөх хөрөнгийн татвар илүү, хувь хүний орлогын албан татвар энэ дүнгээр тус тус дутуу тайлагнагдсан байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын байгууллагад хандан холбогдох татварын тайлангуудад залруулга хийлгэх талаар зөвлөмж өгөх.



- Мөнгөн гүйлгээний тайланд орлогын дэлгэрэнгүй тайлангаас борлуулалтын орлогыг 81.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн гүйлгээний тайланд залруулах талаар зөвлөмж өгөх.

2.9.7 Нягтлан бодох бүртгэлийн талаар

- Байгууллагын ерөнхий нягтлан бодогчоор түр гэрээтэй ажилтанг ажиллуулж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд түүнийг Сангийн яамны зөвшөөрөлтэйгээр захирал томилно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон тооны нягтлан бодогчийг хууль журамд нийцүүлэн томилж ажиллуулах талаар зөвлөмж өгөх.

- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2012 онд батлагдсан НБББББ-ийг мөрдөж байгаа боловч шинэчлэн батлагдсан стандарт, хууль, тушаал зааврын өөрчлөлтийг хийгээгүй байгаа нь нийцэхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж мөрдөж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөх талаар зөвлөмж өгөх

- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжинд тохируулга хийгээгүйгээс санхүүгийн тайлангийн зардлын тодруулга тайланг гаргаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Програм хангамжинд тохируулга хийж, мэдээлийг үнэн зөв гаргаж байх талаар зөвлөмж өгөх

2.9.8 Шилэн дансны талаар


- Шилэн дансны <http://www.shilendans.gov.mn> сайтад тавьсан мэдээллийг шалгахад байгууллагын дарга нягтлан бодогчдын мэдээлэл ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын мэдээллээр байршиж байна. Нийт 18 мэдээлэл байршуулахаас аудит хийгдсэн тайлан, аудитын дүгнэлт, аудитын тайлан дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангаас бусад 15 мэдээллийг байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай 5 дугаар зүйлийн “5.1.3-д “тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх”, 6 дугаар зүйлийн 6.1.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор” гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

- Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.

2.9.9 Төлөвлөгөө, зорилтот түвшний талаар

- Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөнд батлагдсанаас 3 нэр төрлийн материалыг 151.7 сая төгрөгөөр илүү дүнгээр бэлтгэсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн



өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлагналын оршин байх, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалыг үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөнд баталсан хэмжээ, тухайн үеийн хэрэгцээ шаардлага, ашиглах хугацаа зэргийг харгалзан бэлтгэж байх албан шаардлага өгөх.

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 379 тоот тогтоолоор 2017 оны зорилтот түвшингийн нийт орлогыг 6,195.9 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 5,406.2 сая төгрөгийн орлоготой ажиллаж төлөвлөгөөг 789.7 сая төгрөгөөр буюу 12.8 хувиар тасалдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага өгөх.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хан Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2014 оны 4139 дүгээр шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 14 дүгээр магадлал, Улсын дээд шүүхийн 2015 оны 14 дүгээр магадлал, Улсын Дээд шүүхийн хяналтын шатны 2015 оны 167 дугаар тогтоол бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 10 дугаар сарын 17-ны 415 дугаар тогтоолоор Биокомбинат ТӨААТҮГ-ын захиралаар Б.Баттогтохыг эгүүлэн томилсон байна.

Тус байгууллагын Санхүү, эдийн засгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Гэрэлмааг гүйцэтгэх захирлын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Б/26 дугаар тушаалаар чөлөөлж, 2018 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс нягтлан бодогч Б.Байгалмааг 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хугацаа дуустал, түр гэрээгээр ажиллуулж байна.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 1/14377 тоот дансны хаалт, хасалт хийх тухай албан тоотор Биокомбинат ТӨААТҮГ-ын Улаанбаатар хотын банк дахь 2614057656 тоот данснаас 41.2 сая төгрөгийг хасалт хийсэн байна.

Dorgio.com, eagle.mn зэрэг мэдээллийн сайтууд, болон бусад мэдээллийн хэрэгслүүдээр Биокомбинат ТӨААТҮГ-ын захирлын томилгооны талаар мэдээлсэн нь олон нийтийн анхаарлыг татаж байна.

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлын улмаас худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтыг бүрэн шалгаагүй болно.

Түр гэрээгээр ажиллаж байгаа нягтлан бодогч Б.Байгалмаа нь санхүүгийн тайлангийн аудитыг дуусаагүй байхад, санхүүгийн програмын шилжүүлэлтийг хийснээс шалтгаалан, холбогдох залруулгуудыг хийгээгүй бөгөөд 2018 оны 1 дүгээр улиралд хийхээр асуудлын бүртгэлээр тайлбар өгсөн.



2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Биокомбинат ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар нэмж төлөгдсөн капитал дансны бүртгэл, бараа материалын гологдол, ашиглалтаас хасах, худалдан авах ажиллагаа, аудитаар илэрсэн алдааны залруулгуудынталаар дахин хянаж үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Биокомбинат ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,658.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,576.5 сая төгрөгийн алдаанд зөвлөмж өгч, 1,081.7 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгөв.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Биокомбинат ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 6 зөвлөмж өгснөөс 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, Хувь хүний орлогын албан татварыг хуулийн дагуу суутган тооцож, тайланд тусгаж, төсөвт шилжүүлэн ажиллах гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

Биокомбинат ТӨААТҮГ-ын материаллаг байдлын суурийг гүйцэтгэлийн үе шатанд орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 5,095.7 сая төгрөгийн 2 хувиар буюу 101.9 сая төгрөгөөр тодорхойлж баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Биокомбинат ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Биокомбинат ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн “Сөрөг” санал дүгнэлт гаргаж байна.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Биокомбинат ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



Асуудал 1: Байгууллагын санхүүгийн тайланд тусгагдаж ирсэн тодорхойгүй эх үүсвэрүүд болон улсын бүртгэлийн талаар**Тэргүүлэх ач холбогдол №1**Ажиглалт

Тус байгууллага нь 100 хувь төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдэрийн газар боловч нэмж төлөгдсөн капитал дансанд тодорхойгүй эх үүсвэр 124.7 сая төгрөгийг тайлагнаж ирсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 2-т нэмж төлөгдсөн капитал нь компанийн гаргасан энгийн хувьцаа болон давуу эрхтэй хувьцааны зах зээлийн үнэ нэрлэсэн үнээс илүү байвал зөрүүг нэмж төлөгдсөн капитал дансанд хуримтлуулан бүртгэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн 5.1.4-д "үнэн зөв байх" гэж заасныг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг дансанд тодорхойгүй эх үүсвэр 207.9 сая төгрөгийг тайлагнаж ирсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 17-д "Эздийн өмчийн бусад хэсэг"-ийн бүрэлдэхүүн тус бүр (тухайлбал, ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн тогтоосон төлөвлөгөөнөөс үүссэн актаур олз, гарз, санхүүгийн хэрэглүүрийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарз, мөнгөн гүйлгээний хейдж дэхь хейджийн хэрэглүүрээс үүссэн олз, гарз) гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

/ЭҮ,ТТ, ИБ, Х, ҮЗ /

Зөвлөмж

Тодорхойгүй эх үүсвэрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 1: Байгууллагын санхүүгийн тайланд тусгагдаж ирсэн тодорхойгүй эх үүсвэрүүд болон улсын бүртгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

Тус байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 300 гишүүнтэйгээр бүртгэгдсэн нь Төрийн өмчийн хорооны 2004 оны 432 дугаар тогтоолоор баталсан байгууллагын дүрмийн 4.1-т "Үйлдвэрийн газрын хөрөнгө нь дан ганц төрийн өмчийн эд хөрөнгөөс бүрдэх бөгөөд нийт хөрөнгө нь үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгө, биет бус хөрөнгөөс бүрдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Эзэмшигчийн өмчийг санхүүгийн байдлын тайланд 2,141.0 сая төгрөгөөр тайлагнасан нь улсын бүртгэлийн гэрчилгээнд 1,233.6 сая төгрөгөөр бүртгэсэн дүнгээс 907.4 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төрийн өмчийн хорооны 2004 оны 432 дугаар тогтоолоор баталсан байгууллагын дүрмийн 4.2-т "Үйлдвэрийн газрын хөрөнгийн хэмжээнд гарах өөрчлөлтийг жил бүрийн санхүүгийн тайлан тэнцэлд тусгана" гэж заасантай нийцэхгүй байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацааг 1 жилээр бүртгүүлсэн байна.

Зөвлөмж

Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уламжлан шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

/ЭҮ,ТТ, ИБ, Х, ҮЗ /

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 2: Мөнгөн хөрөнгийн талаар**Тэргүүлэх ач холбогдол №2****Ажиглалт**

Нийт 131.8 сая төгрөгийг бэлэн мөнгөний орлогын баримтгүй, 8.3 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.4-т "Аж ахуй нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ" гэж заасныг болон санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Томилолтын зардалд баримтын бүрдэл дутуу 1.3 сая төгрөгийн томилолтыг бодож олгосон байна. Энэ нь Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 22 ны өдрийн 218 дугаар тогтоолын 3.9-д "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог томилолтын үнэмлэхэд тэмдэглэсэн календарийн өдрийн бүх хоногоор тооцож гаргана. Тэгэхдээ явсан, буцаж ирсэн өдрийг нэг хоногт тооцно." гэж заасныг мөрдөөгүй байна.

Зөвлөмж

Ажил гүйлгээ бүрийг хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн бүртгэж байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлэхгүй байх

/ЭҮ,ТТ, ИБ, ҮХ, ҮЗ, /

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 3: Бараа материалын талаар**Тэргүүлэх ач холбогдол №3****Ажиглалт**

Бараа материалын үлдэгдлээс 5 нэр төрлийн хөрөнгөнд хяналтын тооллого хийхэд 2 нэр төрлийн 1.4 сая төгрөгийн бараа материал илүү, 4 нэр төрлийн 7.3 сая төгрөгийн бараа материал дутуу, 3 нэр төрлийн 20.5 сая төгрөгийн бараа материалын хадгалалтын хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэж заасныг мөрдөөгүй байна.

Хугацаа нь дууссан 3 нэр төрлийн 10 орчим тн 9.3 сая төгрөгийн химийн бодисын үлдэгдэлтэй байна.

2017 онд 247.1 сая төгрөгийн гологдол бүтээгдэхүүн, 121.0 сая төгрөгийн шинжилгээний дээжид ашигласан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн өртөгт шингээж бичилт хийсэн байна. Энэ нь байгууллагын мөрдөж байгаа НБББББ-ийн бараа материалын бүртгэлийн бодлогын зарцуулалтын өртөг “бараа материалын хэвийн хорогдлыг үйл ажиллагааны бус зардалд дундаж өртгөөр, акталж устгасан зүйлийг үйл ажиллагааны бус зардалд дундаж өртгөөр” гэж заасныг зөрчсөн байна.

2017 оны жилийн эцсийн тооллогоор 73 нэр төрлийн 9.1 сая төгрөгийн бараа материалыг актлахаар бүртгэсэн боловч, эрх бүхий албан тушаалтны шийдвэр гараагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлэхгүй байх

/ЭҮ,ТТ, ИБ, ҮХ, ҮЗ, /

Зөвлөмж

Бараа материалыг үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөнд баталсан хэмжээ, тухайн үеийн хэрэгцээ шаардлага, ашиглах хугацаа зэргийг харгалзан бэлтгэж байх

Хугацаа хэтэрсэн ашиглах боломжгүй эм бэлдмэлийг холбогдох мэргэжлийн байгууллагад хандан устгах арга хэмжээг авах.талаар зөвлөмж өгөх

Үйлдвэрлэлийн өртөгт оруулан тооцсон гологдол бүтээгдэхүүнийг үйл ажиллагааны бус зардлаар бүртгэж байхөгөх талаар зөвлөмж

Бараа материалыг данснаас хасач тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр гаргуулах талаар зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ

Асуудал 4: Үндсэн хөрөнгийн талаар**Тэргүүлэх ач холбогдол №4****Ажиглалт**

Байгууллагын баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт элэгдэл тооцох арга, ашиглах жилийг тусгаж өгөөгүй нь Засгийн газрын 2014 оны 297 дугаар тогтоолыг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Худалдан авсан 170.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэхдээ худалдан авалтанд төлсөн 15.5 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг капиталжуулаагүй, нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан авалтаар бүртгэсэн байна. Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр бүлгийн 1.5-д “үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлагад үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн 187.4 сая төгрөгөөс 61.4 сая төгрөгийг дутуу тайлагнасан нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын "Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үндсэн хөрөнгийн дансанд нийт 448 төрлийн нийт 3128 ширхэг элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1,862.7 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Эрсдэлүүд

стандарт заавар, журмыг мөрдөхгүй байх.

/ЭҮ,ТТ, ИБ, Х, ҮЗ /

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн НБББББ-т нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөх талаар зөвлөмж өгөх.

Үндсэн хөрөнгийг капиталжуулах, татварын байгууллагад хүсэлт илгээн нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд залруулж бүртгэх талаар зөвлөмж өгөх.

Санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланг залруулах талаар зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, данс бүртгэлээс хасах зэрэг асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 5: Авлага өр төлбөрийн талаар**Тэргүүлэх ач холбогдол №5****Ажиглалт**

Бүүвэй фүүд" ХХК-тай байгуулсан цайны газрыг түрээслүүлэх гэрээний 3.2-т “Цайны газрыг түрээслэхэд барьцаа болгож гурван сарын түрээсийн төлбөр болох 4.8 сая төгрөгийг байгууллагын дансанд байршуулах гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Ажилтан албан хаагчдад олгосон 500.6 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг тооцооны дансаар дамжуулж бүртгээгүй байна.

Цалингийн урьдчилгааг тооцооны дансанд бүртгээгүйгээс үүссэн гүйлгээний утга тодорхойгүй 21.2 сая төгрөгийг авлага дансанд хаасан байна.

Санхүүгийн байдлын тайланд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг санхүүгийн тайлангийн тодруулгад 36.2 сая төгрөгөөр, аж ахуй нэгжийн орлогын албан татварын авлагыг 8.8 сая төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татварын авлагыг 7.7 сая төгрөгөөр, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын өглөгийг 0.01 сая төгрөгөөр, хувь хүнээс суутгасан орлогын албан татварын өглөгийг 3.4 сая төгрөгөөр цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын өглөгийг 1.7 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

Хувь хүний орлогын албан татварт төлөх 26.6 сая төгрөгийн татварыг үл хөдлөх хөрөнгийн татварт шилжүүлснээс үл хөдлөх хөрөнгийн татвар илүү, хувь хүний орлогын албан татвар энэ дүнгээр тус тус дутуу тайлагнагдсан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд борлуулалтын орлогыг 81.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Эрсдэлүүд

Стандарт заавар, журмыг мөрдөхгүй байх.

/ЭҮ,ТТ, ИБ, Х, ҮЗ /

Зөвлөмж

Байгууллагуудтай хийсэн гэрээний заалтыг мөрдөж ажиллах, гэрээг дүгнэж байх талаар зөвлөмж өгөх.

Холбогдох журам, зааварт тусгасны дагуу нягтлан бодох бүртгэлд бүртгэж байх талаар зөвлөмж өгөх.

Авлагыг дэлгэрэнгүй нэрээр залруулж бүртгэх талаар зөвлөмж өгөх.

Татварын байгууллагад хандан холбогдох татварын тайлангуудад залруулга хийлгэх талаар зөвлөмж өгөх.

Мөнгөн гүйлгээний тайланд залруулах талаар зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 6: Зардлын талаар**Тэргүүлэх ач холбогдол №5****Ажиглалт**

Практикал даатгал ХХК-тай байгуулсан 1 жилийн даатгалын гэрээний төлбөрт төлсөн 15.0 сая төгрөгийг тайлант оны зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалын 2.1.5-ын Г-д "Урьдчилж төлсөн зардлыг хэрэгжсэн үед тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө", 2012 оны 77 дугаар тушаалын 7-д "Тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг урьдчилж төлсөн зарлагыг (даатгал, түрээс) гэх мэт санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулж урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд шингээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Ажилтан албан хаагчдад ажлын өдөрт нэг мянга таван зуун төгрөгийн хоолны хөнгөлөлт олгохоор хөдөлмөрийн дотоод журмын цалин хөлсний бодлого горимд заасан боловч, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулаагүй, тушаал шийдвэргүйгээр гурван мянган төгрөгөөр тооцож олгосоноос 38.1 сая төгрөгийг олгосон байна.

Уралдаан тэмцээнд 11.2 сая, хүлээн авалтын зардалд 11.5 сая, баяр ёслолын зардалд 13.5 сая, нийт 32.2 сая төгрөгийг зарцуулсан нь Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын нэгдүгээр хэсэгт "...төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах..." гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Зардал буруу илэрхийлэгдэх, стандарт заавар, журмыг мөрдөхгүй байх.

/ЭҮ,ТТ, ИБ, Х, ҮЗ /

Зөвлөмж

Даатгалын хураамжийг урьдчилж төлсөн зардлаар бүртгэж байх талаар зөвлөмж өгөх

Хоолны хөнгөлөлтийг байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, тушаал шийдвэрээр баталгаажуулах талаар зөвлөмж өгөх

Цаашид үр ашиггүй зардал гаргахгүй ажиллах талаар зөвлөмж өгөх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага төрийн аудитын байгууллага санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 7: Санхүүгийн тайлагналын талаар**Тэргүүлэх ач холбогдол №5****Ажиглалт**

Орлогын дэлгэрэнгүй тайланд тусгасан 5,373.9 сая төгрөгийн борлуулалтын орлого нь гүйлгээ балансаархи борлуулалтын орлогын дүнгээс 1.1 сая төгрөгөөр илүү, нэмэгдсэн өртгийн албан татварт 5,305.9 сая төгрөгөөр тайлагнасан борлуулалтын орлого нь санхүүгийн тайлангийн борлуулалтын орлогоос 68.0 сая төгрөгөөр дутуу тайлагнагдсан нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Ногдол ашигт төлсөн 152.1 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд төлсөн ногдол ашигт тайлагнаагүй байна.

Зөвлөмж

Гүйлгээ баланс болон татварын тайланд залруулах бичилт хийх талаар зөвлөмж өгөх.

Мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаж байх талаар зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, стандарт заавар, журмыг мөрдөхгүй байх.

/ЭҮ,ТТ, ИБ, Х, ҮЗ /

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 8: Нягтлан бодох бүртгэлийн талаар**Тэргүүлэх ач холбогдол №5****Ажиглалт**

Байгууллагын ерөнхий нягтлан бодогчоор түр гэрээтэй ажилтанг ажиллуулж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд түүнийг Сангийн яамны зөвшөөрөлтэйгээр захирал томилно” гэж заасныг зөрчсөн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2012 онд батлагдсан НБББББ-ийг мөрдөж байна. Энэ нь шинэчлэн батлагдсан стандарт, хууль, тушаал заавартай, нийцэхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж мөрдөж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжинд тохируулга хийгээгүйгээс санхүүгийн тайлангийн зардлын тодруулга тайланг гаргаагүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, стандарт заавар, журмыг мөрдөхгүй байх.

/ЭҮ, ТТ, ИБ, Х, ҮЗ /

Зөвлөмж

Орон тооны нягтлан бодогчийг хууль журамд нийцүүлэн томилж ажиллуулах талаар зөвлөмж өгөх.

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөх талаар зөвлөмж өгөх

Програм хангамжинд тохируулга хийж, мэдээлийг үнэн зөв гаргаж байх талаар зөвлөмж өгөх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 9: Шилэн дансны талаар**Тэргүүлэх ач холбогдол №5****Ажиглалт**

Шилэн дансны <http://www.shilendans.gov.mn> сайтад тавьсан мэдээллийг шалгахад байгууллагын дарга нягтлан бодогчдын мэдээлэл ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын мэдээллээр байршиж байна. Нийт 18 мэдээлэл байршуулахаас аудит хийгдсэн тайлан, аудитын дүгнэлт, аудитын тайлан дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангаас бусад 15 мэдээллийг байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай 5 дугаар зүйлийн “5.1.3-д “тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх”, 6 дугаар зүйлийн 6.1.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор” гэж заасныг мөрдөөгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, стандарт заавар, журмыг мөрдөхгүй байх.

/ЭҮ,ТТ, ИБ, Х, ҮЗ /

Зөвлөмж

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшний биелэлт**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,295,636,528.18	1,533,660,663.64
Дансны авлага	114,272,947.00	96,544,347.57
Татвар, НДШ-ийн авлага		45,765,531.57
Бусад авлага	30,592,107.01	39,415,110.00
Бараа материал	2,702,173,364.37	2,568,150,906.20
Бусад эргэлтийн хөрөнгө	37,956,551.11	37,383,622.40
Эргэлтийн хөрөнгийн дүн	4,180,631,497.67	4,320,920,181.38
Үндсэн хөрөнгө	3,849,517,042.75	3,626,086,647.05
Биет бус хөрөнгө	98,689.68	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,849,615,732.43	3,626,086,647.05
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,030,247,230.10	7,947,006,828.43
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Дансны өглөг	84,779,336.41	39,414,969.43
Цалингийн өглөг	154,555.99	
Татварын өглөг	221,462,993.15	34,877,264.50
НДШ өглөг		
Бусад богино хугацаат өр төлбөр	101,520.00	963,522.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	306,498,405.55	75,255,755.93
Бусад урт хугацаат өр төлбөр	85,706,870.92	79,278,855.67
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн дүн	392,205,276.47	154,534,611.60
Өмч Төрийн	2,141,020,492.31	2,141,020,492.31
Нэмж төлөгдсөн капитал	127,757,408.56	127,757,408.56
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,467,293,059.28	1,467,293,059.28
Хуримтлагдсан ашиг	3,694,182,695.10	3,848,612,958.30
Эздийн өмчийн бусад хэсэг дүн	207,788,298.38	207,788,298.38
Эздийн өмчийн дүн	7,638,041,953.63	7,792,472,216.83
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	8,030,247,230.10	7,947,006,828.43

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого	5,206,401,522.55	5,272,212,217.52
Борлуулалтын өртөг	3,991,004,933.80	3,995,745,564.47
Нийт ашиг/алдагдал	1,215,396,588.75	1,276,466,653.05
Хүүгийн орлого	37,081,049.84	32,312,403.48
Бусад орлого	72,634,577.11	101,686,143.32
Борлуулалт маркетингийн зардал	65,362,529.04	304,416,239.63
Ерөнхий ба удирдлагын зардал	630,168,365.60	684,087,636.34
Санхүүгийн зардал		
Бусад зардал	59,607,105.43	74,138,724.27
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз		(68,902.87)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	569,974,215.63	347,753,696.74
Орлогын албан татвар	62,949,382.51	37,236,847.53
Татварын дараах ашиг/алдагдал	507,024,833.12	310,516,849.21

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,141,020,492.31	127,757,408.56	1,467,293,059.28	207,788,298.38	3,225,600,781.98
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг					(38,442,920.00)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					507,024,833.12
2016 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,141,020,492.31	127,757,408.56	1,467,293,059.28	207,788,298.38	3,694,182,695.10
Нягтлан бодох бодлогын өөрчлөлтийн нөлөө , алдааны залруулга					501,217.63
Өмчид гарсан өөрчлөлт					(4,480,363.64)
Зарласан ногдол ашиг					(152,107,440.00)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					310,516,849.21
2017 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,141,020,492.31	127,757,408.56	1,467,293,059.28	207,788,298.38	3,848,612,958.30

/төгрөгөөр/



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Мөнгөн орлогын дүн	7,570,771,213.36	5,972,476,911.67
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,506,906,761.83	5,920,540,107.55
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	564,000.00	
Бусад мөнгөн орлого	63,300,451.53	51,936,804.12
Мөнгөн зарлагын дүн	6,380,325,857.14	5,640,716,475.07
Ажиллагчдад төлсөн	1,661,215,866.12	1,791,865,119.75
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	499,249,171.58	497,702,560.82
Бараа материал авахад төлсөн	3,462,545,483.45	2,212,144,340.99
Ашиглалтын зардалд төлсөн	4,897,071.43	2,584,360.19
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,151,700.00	2,861,050.00
Татварын байгууллагад төлсөн	549,704,673.59	839,895,716.92
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө		
Бусад мөнгөн зарлага	200,561,890.97	293,663,326.40
Үндсэн үйл ажиллагааны цэвэр монгон гүйлгээний дүн	1,190,445,356.22	331,760,436.60
Мөнгөн орлогын дүн	37,081,049.84	32,312,403.48
Хүлээн авсан хүүний орлого	37,081,049.84	32,312,403.48
Мөнгөн зарлагын дүн	-	126,032,704.62
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		126,032,704.62
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	37,081,049.84	(93,720,301.14)
Мөнгөн орлогын дүн	-	-
Мөнгөн зарлагын дүн	-	16,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		16,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(16,000.00)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,227,526,406.06	238,024,135.46
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	68,110,122.12	1,295,636,528.18
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,295,636,528.18	1,533,660,663.64

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшний биелэлт

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 он	2017 он		харьцуулалт	
		Зорилт	Биелэлт	тоо	хувь
НИЙТ ОРЛОГО : Үүнээс	5,316.1	6,195.9	5,406.2)789.7(87.2%
Улсын захиалгат вакцин, био бэлдмэл шалгаж баталгаажуулах төлбөр / гэрээт ажил /	5,206.4	6,084.1	5,272.2)811.9(86.6%
Нийт зардал : үүнээс	4,746.2	6,000.0	5,058.5)941.5(84.3%
Удирдлагын зардал	630.2	362.2	684.1	321.9	188.9%
Бусад зардал	59.6			-	
Татвар төлөхийн өмнөх ашиг	569.9	195.9	347.7	151.8	177.5%
Цэвэр ашиг	507.0	176.3	310.5	134.2	176.1%
төрийн өмчийн ногдол ашиг	38.4		152.1	152.1	
Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	0.90	0.95)0.95(
Нийт авлага	144.9	16.3	181.6	165.3	+ 11 дах
Нийт өр төлбөр	306.4	10.0	154.5	144.5	+15.4 дах
бусад өглөг				-	
Хөрөнгө оруулалт	243.5	577.6	205.6)372.0(35.5%
Нийт ажиллагсдын тоо	254.0	254.0	254.0	-	100%
Нийт цалингийн сан	2,115.8	2,252.7	2,178.5)74.2(96.6%

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ